

Living the Lotus 3

Buddhism in Everyday Life

2025
VOL. 234



Энэтхэгийн Рисшо Косей кай: Дэли, Гая, Асам хэсэг

Living the Lotus Vol. 234 (2025.03)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Байгаль дэлхийн ач буян

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Хүн бол байгалийг “сүйтгэгч”

Одоо дахин хэлэх нь илүүц байж мэдэх ч, хүмүүс бид өөрөөсөө бусад хамаг юмсын ачаар амьдардаг. Ялангуяа нар, ус, агаар байхгүй бол хүн төдийгүй нэг ч амьд амьтан орших боломжгүй. Ингээд бодоход л “байгаль дэлхийн ач буян”-ыг хангалттай ойлгох буй за.

Гэтэл бид байгаль дэлхийн ач буянд талархахаа мартчихдаг. Түгээр ч үл барам оюун ухаант хүн хамгийн мундаг нь гэж эрдэж бардамнан, амар хялбар, таатай амьдралын төлөө байгаль эх дэлхийг сүйтгэсээр байна. Өргөн уудам байгаль дэлхийн зүгээс харах юм бол хүмүүс бид “сүйтгэгч”-ээс өөр хэн ч биш юм.

Японы бурхны шашны Ринзаи урсгалын багштан Аюкава Хакүдоо гуай хошин өнгө аясаар хүн төрөлхтний дарангуйллыг зэмлэн сануулдаг. “Хөөе хөөе хүн та сонс. Бид он удаан жил оршин буйдаа талархаж, эх дэлхийг хайрлан хамгаалсаар ирсэн. Гэтэл нялх балчир та нар дур зоргоороо эвдэлж хэмхэлж байна. Бид нараас бага зэрэг ухаантай байлаа гээд дураараа аашилж болно гэж үү.” (Мёошин хийд, “Сургаалын түүвэр”-ээс) Байгаль дэлхийд талархаж, ирээдүй хойч үедээ үзэсгэлэнт сайхан дэлхийг уламжлан үлдээх нь хүн төрөлхтөн бидний ухаан гэж тэрээр тодотгон хэлсэн байдаг.

“Өвс мод, газар дэлхий бүгд бурхан”, “Хамаг юмс бурханлаг чанартай” гэхчилэн хэлдэг шиг Японы бурхны шашинд уул толгод ч, гол горхи ч, өвс урагмал ч, мод бут ч бүгд Бурханы нэг хэсэг гэж үздэг. Философич Үмэхара Такэши (1925-2019) гуай энэ үзэл санааг хүн төрөлхтөн нийтээрээ ухамсарлаж, өргөн уудам байгаль дэлхийн ач буяныг мэдэрч, нандигнан хайрлах сэтгэлтэй болох нь нэн тэргүүний асуудал гэж онцлон хэлж байсан.

Хүн гэдэг зовлон бэрхшээлтэй учрахгүй л бол үнэн сэтгэлээсээ өөртөө дүгнэлт хийдэггүй муу зантай. Угтаа зовлон ирэхээс өмнө нэг өдрийн наана ч болтугай нар, агаар, усны ач буяныг ухамсарлаж, амьдралаа засаж өөрчилөхөд дорвитой анхаарбал зохилтой.



“Бусдын ач буян” гэсэн сэтгэлтэй байх нь жаргал

Урьд өмнө Огасавара арал руу явах үед усан онгоц дээрээс далайн зах хязгаарт өглөөний нар мандаж, үдийн нар хэлбийх үзэсгэлэнт байгалийг хараад сэтгэл хөдлөн биширч, сэтгэл угаагдан ариусахын зэрэгцээ уудам байгаль дэлхийн ачаар амьд яваагаа гүнзгий ухаарч байсан билээ. Гадаа өвс ургамал, цэцэг навч хичээнгүйлэн ургаж байгааг хараад сэтгэл баясан догдлох хүн, цементэн замын цоорхойгоор дэлбээлэн ургасан жижигхэн багваахай цэцгийг хараад амьдралын эрч хүчийг олж авах хүн ч байгаа байх. Бид байгаль дэлхийтэй нэг амьтай болохоор л ингэж мэдэрдэг болов уу. Нэгэн сэтгэл заслын эмч цэцэг ногоо, өвс ургамалд анхаарлаа хандуулан нэгэн бүхэл болсноор сэтгэл санаа уужирч, эрч хүч сэтгэх явдал цөөнгүй бий гэж хэлж байсан. Хүмүүс бид сэтгэл санааны хувьд ч, бие махбодын хувьд ч нар, ус, агаар зэрэг агуу байгаль дэлхийгээс “ач тус”-ыг нь хүртэж байдаг.

Үүнийг сайтар ойлгох аваас хүн даруу төлөв, зөв амьдардаг болно. Жишээлбэл нар хийгээд усны ачаар хоолны ширээн дээр идэх хоол байгааг ухаарах юм бол хэтрүүлэн идэхгүй, хоолны хаягдал гаргахгүй байхыг хичээж, ус зэрэг байгалийн нөөцийг аливч хямгатай хэрэглэх арга замыг сонгох нь лавтай. Ингэж амьдрах нь их бага хэмжээгээр төвөгтэй, дутагдалтай, заг зав үрсэн байж болох ч “бусдын ач буянаар амьдарч байгаа” гэдгээ ухамсарлах юм бол баярлаж талархах сэтгэлээр хүлээж авч чадна. Түүнчлэн ийм сэтгэлтэй байх аваас бид аврагдаж, аз жаргалтай болно.

Гэхдээ сэтгэл ханамжгүй, уур уцаартай байхаар “бусдын ач буян” гэж бодох сөхөөгүй байдаг. Ийм үед байгаль дэлхийн хууль (туйлын үнэн)-ыг эргэн санаж, түүнд талархах хэрэгтэй. Ингэснээр зовлон бэрхшээл дунд байсан ч “бусдын ач буян”-ыг анзаарч, аз жаргалыг мэдэрч, сэтгэлийн амар амгаланг олно.

Туйлын үнэнийг ухаарч ойлгох чадвартай хүн болон мэндэлж, одоо амьд мэнд яваа нь өөрөө хэдийн тэр чигээрээ “бусдын ач буян” билээ. Тус нийгэмлэг үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хэлж дамжуулж ирсэн энэ ач буяныг цаашид ч гэсэн хамтдаа түгээн дэлгэрүүлж, хүн бүрийн “бусдын ач буян” гэсэн сэтгэл нэгдэн нийлэх орчлон ертөнцийг бүтээцгээе.

“Косей” сэтгүүл, 3-р сарын дугаараас



Зургийн тайлбар:

Нивано ерөнхийлөгч 27 дахь удаагийн “Ниваногийн нэрэмжит энхтайвны шагнал”-ын эзэн Энэтхэгийн ХАА эрхлэгч эмэгтэйчүүлийн холбооны үүсгэн байгуулагч Эла Рамеш Бхаттай ярилцаж буй нь. (Токио хот, 2010 он)

Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Энхтайвны үйл ажиллагаа

Дэлхийн шашны энхтайвны чуулга

Дэлхийд янз бүрийн шашин байдаг. Тэд бүгд дэлхийн энхтайвныг хүсдэг. Даян дэлхийн сүсэгтнүүд гар нийлэн энх тайвны талаар ярилцаж, түүний төлөө үйл ажиллагаа явуулдаг болохын тулд Үүсгэн байгуулагч шашны удирдагчидтай хамтран “Дэлхийн шашны энхтайвны чуулган”-ыг үүсгэн байгуулсан.

Анхны чуулга уулзалт 1970 онд Киото хотод зохион байгуулагдсан ба түүнээс хойш дэлхийн өнцөг булан бүрт дөрвөн жил тутамд нэг удаа зохион байгуулагдаж байна. 2006 оны 8-р чуулгыг Үүсгэн байгуулагчийн мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан Киото хотноо зохион байгуулж байжээ.




Бяцхан мэдлэг

Дэлхийн шашны энхтайвны чуулгын анхдугаар их хурлаар “зэр зэвсгийг эсэргүүцэх”, “ололт нээлт”, “хүний эрх” зэрэг дэлхий нийтийн асуудлууд дахь шашинтнуудын оролцооны талаар хэлэлцсэн. Түүнээс хойш “байгаль орчин”, “боловсрол”, “эмэгтэйчүүдийн эрх” зэрэг асуудал дээр ч мөн санаа тавин ажилладаг.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Нэг удаагийн хоолоо хандивлах хөдөлгөөн



Дэлхийд өлсгөлөнд нэрвэгдэн нас барж, хоол тэжээлийн дутагдлын улмаас өвчнөөр шаналж буй олон хүн бий. Тэдний зовлон зүдгүүрийг ойлгож, өлсгөлөн, өвчин зовлонгүй болохын төлөө залбирч, хүн бүрийн аз жаргалын төлөө дэмжлэг үзүүлэх нь “Нэг хоолоо хандивлая хөдөлгөөн”-ий зорилго юм.

Рисшо Косэй-Кай нийгэмлэгийн гишүүд сар бүрийн 1, 15-ны өдрүүдэд 1 удаагийн хоолны мөнгөө дотоод болон гадаадын тусламжийн үйл ажиллагаанд хандивладаг.

Бяцхан мэдлэг

Энэ хөдөлгөөний үндэс суурь нь Эдогийн үеэс эхлэлтэй. Тэнпогийн үед болсон их өлсгөлөнгийн үеэр Мисоги шашны урсгалыг үндэслэгч Иноүэ Масаканэ өлсгөлөнд нэрвэгдсэн ард түмэнд нэг удаагийн хоолоо хандивлахыг уриалж, тусламжийг эхлүүлсэн нь энэ хөдөлгөөний үүсэл гэгддэг.

* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.

Байгаль дэлхийгээс суралцахуй

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу?

Гуравдугаар сар гарч, цаг агаар дулаарч байна.

Энэ сард нийгэмлэг үүсэн байгуулагдсаны 87 жилийн ойн ёслолын ажиллагаа болохоос гадна Нивано ерөнхийлөгчийн 88 насны (хий насаар) ойг тэмдэглэх тусгай хөтөлбөр (жилийн турш 8 удаа болно) эхлэх зэрэг баяр хөөр дүүрэн сар болох төлөвтэй.

Энэ сарын айлдвар “Байгаль дэлхийн ач буян” гэсэн сэдэвтэй байлаа. Би айлдварыг дахин дахин уншиж, утгыг нь гүнзгий тунгаан бодсон. Тэгээд “зовлон бэрхшээлтэй учрахгүй л бол үнэн сэтгэлээсээ өөртөө дүгнэлт хийдэггүй муу зуршил”-аа орхиж, дотоод сэтгэлээ шинжин, Бурханы бэлгэ билгийг эзэмшихийн төлөө номын мөрд шамдахаа тангараглав. Хавар ирж, байгаль дэлхий сэргэж эхлэх энэ үеэр “Бид бусдын ачаар амьд явдаг” гэдгийг, “Бусдын ачийг мэдэрч даруу төлөв, талархсан сэтгэлээр амьдрах”-ын утга учрыг бодитоор ойлгож авлаа.

Мөн Нивано ерөнхийлөгчийн байнга иш татдаг Ниномия Сонтоку гуайн “Тэнгэр газар дуу чимээ, үнэр үл гарган ямагт бичиг үсэггүй судрыг номломуй.” хэмээх шүлэг санаанд орж байна. Хаврын нахиа, байгаль дэлхийн өөрчлөлтийг судрын мөрт болгон таван мэдрэхүйгээрээ мэдрэхийн зэрэгцээ миний амьдралын хэв маяг туйлын үнэнд нийцэж байна уу гэж өөрөөсөө асууж, энэ сард ч бас бурхны үйлд хичээх болно.




Акагава дарга 1 сарын 18-нд Солонгосын Бусан хэсгээр зочилж, өвлийн номын уншлагад оролцсон нь

Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp